



ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 11/БН

Бэрх хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн ирүүлсэн чиглэлийг хүрээнд Орон нутгийн хэмжээд оршуулгын газар олгох, үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулахтай холбогдсон хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бахыт (Захирагчийн орлогч)

Ажлын хэсгийн

нарийн бичиг:

Т.Очирбат (ЗАА-ны Газрын даамал)

Гишүүд:

Б.Энхдөл (ЗАА-ны Байгаль хамгаалагч)

Б.Мөнбиш (Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

М.Мөнх-Эрдэнэ (Батноров сумын сум дундын цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч)

2. Хяналт шалгалтыг удирдамж, төлөвлөгөө гарган, удирдлага зохион байгуулалтаар ханган, үр дүнг тооцож ажиллах, тайлан мэдээг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Бахыт)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (Э.Мягмарсүрэн)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН

232501054